



114

МОНГОЛ УЛСЫН  
БОЛОВСРОЛ, СОЁЛ, ШИНЖЛЭХ УХААНЫ  
САЙДЫН ТУШААЛ

2016 оны 05 сарын 26 өдөр

Дугаар 1/2016

Улаанбаатар хот

Г Тушаалд өөрчлөлт оруулах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.2 дахь хэсэг, Дээд боловсролын санхүүжилт, суралцагчдын нийгмийн баталгааны тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.7 дахь хэсэг, Монгол Улсын Засгийн газрын 2012 оны "Журам батлах тухай" 19 дүгээр тогтоолоор батлагдсан "Дээд боловсролын сургалтын байгууллагад суралцагчид сургалтын төлбөрийн болон амьжиргааны зардлын зээл олгох журам"-ыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Боловсрол, соёл, шинжлэх ухааны сайдын "Сургалтын төрийн сангийн зээлийн санхүүжилтээр гадаадад суралцуулах тухай" 2014 оны А/155 дугаар тушаалын хавсралт дахь Заяамандах овогтой Ундраа-д холбогдох "Массачусетсийн их сургууль" гэснийг "Бостоны их сургууль" гэж, 2015 оны А/22 дугаар тушаалын хавсралт дахь Мөнхжаргал овогтой Чимэддорж-д холбогдох хэсгийн "Харвардын их сургууль" гэснийг "Оксфордын их сургууль" гэж, 2016 оны А/102 дугаар тушаалын хавсралт дахь Багаажав овогтой Ариунсанаа-д холбогдох хэсгийн "Мелбурний их сургууль" гэснийг "Нью-Йоркийн их сургууль" гэж, Вандансүрэн овогтой Ариунаа-д холбогдох хэсгийн "Миннесота их сургууль" гэснийг "Тайд Уотэр их сургууль" гэж, Баасандорж овогтой Анхбаяр-т холбогдох "Маквуайр их сургууль" гэснийг "Пүрдүүгийн их сургууль" гэж тус тус өөрчилсүгэй.

2. Суралцагчтай зохих журмын дагуу гэрээ байгуулж, холбогдох сургуулийн Нэхэмжлэхийн дагуу төлбөр, тооцоо хийхийг Сургалтын төрийн сан /П.Лхагвасүрэн/-д, Энэхүү тушаалын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Дээд боловсролын хэлтэс /П.Эрхэмбулган/-т тус тус даалгасугай.



Л.ГАНТӨМӨР